




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3315 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
9.3%



НИЙТ ХАДГАЛАМЖ
18 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
33.3 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
1031 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
9%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 4-р сарын байдлаар 292.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 45.8 хувиар өссөн бол, зарлага 3.5 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 292.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 40.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 140 төгрөгөөр өсжээ.

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 192 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 140 төгрөгөөр өсөж 3041.90 төгрөг болов. 4-р сард гадаад валютын нөөц 3.3 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -0.12 оны эхнээс 26.89 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 32.24 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 14.4%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 4-р сарын байдлаар өмнөх сараас 2.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар, оны эхнээс 6.4 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувь, соггууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 12.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 15.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 25.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 450 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны дөрөвдүгээр сард нийт барааны эргэлт 5148.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 15 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 12 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 450 сая ам.долларын ашигтай гарав.



4-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.1212.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 4-р сард өмнөх сараас 3.1 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 28.9 хувиар тус тус өсөж 22.7 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2135 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.5 хувиар өсөж, өнгөрсөн оны мөн үеэс 7.1 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.3% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 4 дүгээр сарын эцэст 996.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 27.3 (2.8%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 289.4 (22.5%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.4 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ БОДИТ НИЙТ ОРЛОГО ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 7.6 ХУВИАР ӨСӨВ.

- Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2022 оны 1дүгээр улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 335.7(23.2%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 142.9(8.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЭКСПОРТ ӨМНӨХ САРААС 18.7 ХУВИАР ӨСЛӨӨ

- Монгол улс 2022 оны эхний 4 сард нийт 134 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.8 тэрбум америк доллар, импорт 2.3 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 690.8(15.5%) сая америк доллароор, экспорт 302.7(12.1%) сая америк доллароор, импорт 388.1(19.8%) сая америк доллароор тус тус өсжээ. Мөн экспорт өмнөх сараас 138.1 (18.7%) сая америк доллароор, импорт 5.7(0.9%) сая америк доллароор тус тус өссөн байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2022 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn